



13

**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 69

Мандалговь

┌ Түрээсийн төлбөрийг түр хугацаагаар ┐  
хөнгөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай журам”-ийн 8 дугаар зүйлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Тухайн салбарын онцлог, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан Нийтлэг үйлчилгээ, үйлдвэрийн газрын эзэмшилд байгаа “Өвлийн нарлаг хүлэмж” болон Ёслол хүндэтгэлийн өргөөний хоолны газар нь улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан үйл ажиллагаа нь доголдож, ашиг орлого муудсаныг харгалзан үзэж 2020 оны 05 сарын 01-нээс 2020 оны 12 сарын 31 өдрийг хүртэлх хугацаанд түрээсийн төлбөрийг 50 хувь бууруулахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Нийтлэг үйлчилгээ, үйлдвэрийн газрын дарга (Ё.Дашням)-д ажиллахыг даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

